



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

2024.05.13 № А-1/1999  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендер шалгаруулалтын  
тухай**

Тус газраас зарласан БШУЯ/20240102154 дугаартай "ХIII.1.3.22 Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/" УТ2401502573 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын аргыг Боловсрол, шинжлэх ухааны сайд 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/214 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулж, ерөнхий гэрээний арга болгосон байна.

Иймд тус газраас зарласан дээрх төсөл, арга хэмжээний нээлттэй тендер шалгаруулалтыг хүчингүй болгож байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 21/1887 дугаар албан бичгийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 4 хуудастай.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324025115



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-22-27, И-мэйл: letter@mecs.gov.mn  
Вэб сайт: meds.gov.mn

2024.05.07 № 21/1887  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хамтран ажиллах тухай

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн "Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" А/83 дугаар тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/214 дүгээр тушаал болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан "XIII.1.3.22 Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/" төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авах тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг шинэчлэн баталсныг тус тус хавсралтаар хүргүүлж байна.

Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу шуурхай зохион байгуулж, хамтран ажиллахыг хүсье.

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Х.ТАМИРАА



14249 2060



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/214

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5 дахь заалт, 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн "Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" А/83 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын 3 дахь заалт "Боловсролын байгууллагын тоног төхөөрөмж (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)", 19 дэх заалт "Боловсролын салбарын тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянгол дүүрэг)" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мөрдөх журам "Нээлттэй тендер шалгаруулалт" гэснийг "Ерөнхий гэрээ" гэж, 12 дахь заалт "Боловсролын салбарын тоног төхөөрөмж (Улаанбаатар, Багануур, Налайх, Багахангай дүүрэг)" төсөл, арга хэмжээ "500.0 сая төгрөг - Нээлттэй тендер шалгаруулалт" гэснийг "400.0 сая төгрөг - Нээлттэй тендер шалгаруулалт", "100.0 сая төгрөг - Ерөнхий гэрээ" гэж, 14 дэх заалт "Боловсролын салбарын тоног төхөөрөмж (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг)" төсөл, арга хэмжээ "450.0 сая төгрөг - Нээлттэй тендер шалгаруулалт" гэснийг "Ерөнхий гэрээ" гэж, 17 дахь заалт "Боловсролын салбарын тоног төхөөрөмж (Хөвсгөл) төсөл, арга хэмжээ "1,000.0 сая төгрөг - Нээлттэй тендер шалгаруулалт" гэснийг "333.9 сая төгрөг - Нээлттэй тендер шалгаруулалт", "666.1 сая төгрөг - Ерөнхий гэрээ" гэж тус тус өөрчилсүгэй.

2.Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шуурхай зохион байгуулахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), Нийслэлийн боловсролын газар (Б.Амартүвшин) нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14241 0764

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

БАТЛАВ

Х.БАТЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТААР "БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ" /УЛААНБААТАР,  
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ/ ХУДАЛДАН АВАХАД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ

№	Тоног төхөөрөмж	Техникийн тодорхойлолт		Тоо, ширхэг
1	Ухаалаг самбар /65 инч/	Дэлгэцийн хэмжээ	65 inch /multi-touch/	50
		Дэлгэцийн нягтрал	3840*2160 /4K UHD/	
		Харагдах өнцөг	178 (H/V)	
		Audio and Speakers	Микрофон: 8m distance	
		Wireless	Утасгүй интернет холбогдох боломжтой	
		Camera	Онлайн хуралд зориулсан камер 13MP болон түүнээс дээш	
		Touch	Мэдрэгчийн технологи: Infrared, 20-оос багагүй хуруу зэрэг мэдэрдэг байх бөгөөд хуруугаараа бүх зүйлийг удирдах боломжтой байх	
		Ports	Type C, AUDIO, USB, HDMI, RJ-45 болон бусад	
		Lifespan	30000 цагаас дээш	
		Windows процессорын үзүүлэлт	CPU-i5-11th generation болон сүүлийн хувилбар RAM - 8GB DDR4 болон түүнээс дээш Hard drive 512 GB SSD болон түүнээс дээш	
		Android процессорын үзүүлэлт	RAM-4 GB болон түүнээс дээш ROM-32GB болон түүнээс дээш	
		Operating system	Windows 11, Android 10.0 болон түүнээс дээш	
		Дагалдах хэрэгсэл	Утасгүй гар, хулгана, тэжээлийн залгуур, зориулалтын үзэг (2ш), заагч, хананд тогтоогч, Утасгүй дэлгэц шилжүүлэгч төхөөрөмж /Жишээ нь: Dongle гэх мэт/	
		Хөл / Mobile Stand 55"-80"	Дэлгэцийн хэмжээ - 55-80 инч болон түүнээс дээш, Даац - 90кг-аас багагүй, Төрөл - Бүх төрлийн ТВ-нд тохиромжтой, 4 дугуйтай хөлтэй	
		Баталгаат хугацаа	24 сар болон түүнээс дээш	

Хянасан:

Цахим бодлого, статистик мэдээллийн газрын дарга

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Боловсруулсан:

Цахим бодлого, статистик мэдээллийн газрын ахлах шинжээч

Т.Бат-Эрдэнэ

Х.Тамираа

О.Дүнжиннамдаг

БАТЛАВ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Х.БАТЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР "БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ" /УЛААНБААТАР, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ/ ХУДАЛДАН АВАХАД ТАВИГДАХ  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Тоног төхөөрөмж	Техникийн тодорхойлолт	Тоо, ширхэг	Нэгж үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/	
1	Ухаалаг самбар /65 инч/	Дэлгэцийн хэмжээ	65 inch /multi-touch/	50	9,000	450,000
		Дэлгэцийн нягтрал	3840*2160 /4K UHD/			
		Харагдах өнцөг	178 (H/V)			
		Audio and Speakers	Микрофон: 8m distance			
		Wireless	Утасгүй интернет холбогдох боломжтой			
		Camera	Онлайн хуралд зориулсан камер 13MP болон түүнээс дээш			
		Touch	Мэдрэгчийн технологи: Infrared, 20-оос багагүй хуруу зэрэг мэдэрдэг байх бөгөөд хуруугаараа бүх зүйлийг удирдах боломжтой байх			
		Ports	Type C, AUDIO, USB, HDMI, RJ-45 болон бусад			
		Lifespan	30000 цагаас дээш			
		Windows процессорын үзүүлэлт	CPU-i5-11th generation болон сүүлийн хувилбар RAM - 8GB DDR4 болон түүнээс дээш Hard drive 512 GB SSD болон түүнээс дээш			
		Android процессорын үзүүлэлт	RAM-4 GB болон түүнээс дээш ROM-32GB болон түүнээс дээш			
		Operating system	Windows 11, Android 10.0 болон түүнээс дээш			
		Дагалдах хэрэгсэл	Утасгүй гар, хулгана, тэжээлийн залгуур, зориулалтын үзэг (2ш), заагч, хананд тогтоогч, Утасгүй дэлгэц шилжүүлэгч төхөөрөмж /Жишээ нь: Dongle гэх мэт/			
		Хөл / Mobile Stand 55"-80"	Дэлгэцийн хэмжээ - 55-80 инч болон түүнээс дээш, Даац - 90кг-аас багагүй, Төрөл - Бүх төрлийн ТВ-нд тохиромжтой, 4 дугуйтай хөлтэй			
Баталгаат хугацаа	24 сар болон түүнээс дээш					

Хянасан:

Цахим бодлого, статистик мэдээллийн газрын дарга

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Боловсруулсан:

Цахим бодлого, статистик мэдээллийн газрын ахлах шинжээч

Т.Бат-Эрдэнэ

Х.Тамираа

О.Дүнжиннамдаг